



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
(2020-2024 ОН)

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ ХЭЛЛЭГ	2
1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	4
2. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ	4
2.1. Геологийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж	5
2.2. Уул уурхайн бодлого хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж.....	7
2.3. Газрын тосны бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж	7
2.4. Хүнд үйлдвэрийн бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж	8
2.5. Төрийн захиргааны удирдлагын бодлого хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж	9
2.6. Судалгаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж	10
2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж	11
3. АЛСЫН ХАРАА	12
4. ЭРХЭМ ЗОРИЛГО	12
5. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	12
5.1. Геологийн салбар	12
5.2. Уул уурхайн салбар	14
5.3. Газрын тосны салбар.....	15
5.4. Хүнд үйлдвэрийн салбар.....	17
5.5. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль, эрх зүйн орчин.....	18
5.6. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын орчин.....	19
5.7. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хүний нөөц... 21	
6. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	24
7. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ.....	24
8. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ	26
(2020-2024 ОН).....	26

ТОВЧИЛСОН ҮГ ХЭЛЛЭГ

УИХ	Улсын Их Хурал
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
СЯ	Сангийн яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЗТХЯ	Зам тээврийн хөгжлийн яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХЯ	Батлан хамгаалах яам
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
ҮГА	Үндэсний геологийн алба
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ШУА	Шинжлэх ухааны академи
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
МУИС	Монгол Улсын их сургууль
ШУС	Шинжлэх ухааны сургууль
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн сургууль
ГУУС	Геологи, уул уурхайн сургууль
ХШУС	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль
МТС	Мэдээлэл технологийн сургууль
ГХ	Геологийн хүрээлэн
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ПХ	Палеонтологийн хүрээлэн
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
АЕГ	Архивын ерөнхий газар
ҮДТ	Үндэсний дата төв
МГТБҮ	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр
ЭБМЗ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ТББ	Төрийн бус байгууллага
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
ҮТП	Үйлдвэрлэл, технологийн парк
ҮЧҮ	Үндсэн чиг үүрэг
ДЧҮ	Дэд чиг үүрэг

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.” гэж заасан.

Энэ хүрээнд Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд энэхүү журмыг үндэслэн Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын 2020-2024 оны Стратеги төлөвлөгөө Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/81 дугаар тушаалаар батлагдсан.

Энэхүү тушаалын 2 дахь хэсэгт заасны дагуу салбарын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны стратеги төлөвлөгөөг боловсруулав.

2. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дор дурдсан 36 хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

Яамны үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулиуд:	<ol style="list-style-type: none">1. Монгол Улсын Үндсэн хууль;2. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;3. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль;4. Ашигт малтмалын тухай хууль;5. Авилгын эсрэг хууль;6. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;7. Ахмад настны тухай хууль;8. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;9. Газрын хэвлийн тухай хууль;10. Газрын тосны тухай хууль;11. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль;12. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль;13. Галын аюулгүй байдлын тухай хууль;14. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль;15. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль;16. Захиргааны ерөнхий хууль;17. Инновацийн тухай хууль;18. Компанийн тухай хууль;19. Нийгмийн даатгалын тухай хууль;
---	---

	<p>20. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;</p> <p>21. Төсвийн тухай хууль;</p> <p>22. Төрийн албаны тухай хууль;</p> <p>23. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;</p> <p>24. Төрийн болон албаны нууцын тухай хууль.</p> <p>25. Технологи дамжуулах тухай хууль;</p> <p>26. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай;</p> <p>27. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль;</p> <p>28. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;</p> <p>29. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль;</p> <p>30. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль;</p> <p>31. Хууль тогтоомжийн тухай хууль;</p> <p>32. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;</p> <p>33. Хөдөлмөрийн хууль;</p> <p>34. Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль;</p> <p>35. Хог хаягдлын тухай хууль;</p> <p>36. Цөмийн энергийн тухай хууль.</p>
--	--

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны бүтцийн нэгжүүдийн ерөнхий, үндсэн болон дэд чиг үүргүүдийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

2.1. Геологийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж

Ерөнхий чиг үүрэг-1: Геологийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Геологийн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах.	ДЧҮ-1: Геологийн салбарын бодлого, хөтөлбөр, хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар, ангилал, зөвлөмжийн төсөл боловсруулах, батлуулах.	ЗГХЭГ, СЯ, ХЗДХЯ, ГХЯ, ҮГА, АМГТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.
	ДЧҮ-2: Геологийн салбарын бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах.	ҮГА, АМГТГ, ШУА-ийн ГХ болон ПХ, салбарын холбоод, их сургууль, аж ахуйн нэгжүүд.

	<p>ДЧУ-3: Геологийн шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хөгжлийн урт хугацааны бодлого, хууль тогтоомжийн төслийн судалгаа хийх, хэрэгжилтийг хангах, салбарын үйл ажиллагааг нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах.</p>	<p>ҮГА, АМГТГ, ШУА-ийн ГХ болон ПХ, МУИС-ын ШУС, ШУТИС-ын ГУУС, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд, хэвлэл мэдээллийн байгууллага.</p>
<p>ҮЧҮ-2: Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлж, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах.</p>	<p>ДЧУ-4: Бүх төрлийн геологийн судалгаа, хайгуулын ажлыг төлөвлөх, төсвийн саналыг боловсруулах, нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг тодорхойлох, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих.</p>	<p>ХХЕГ, ҮГА, АМГТГ, ГХ, ПХ, аймаг, нийслэлийн ЗДТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.</p>
<p>ҮЧҮ-3: Геологи-хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг өсгөх.</p>	<p>ДЧУ-5: Ашигт малтмалын геологи-хайгуулын ажлын хэмжээг нэмэгдүүлэх, улсын эрдэс баялгийн нөөцийг өсгөх ажлыг зохион байгуулах, хяналт тавих.</p>	<p>АМГТГ, ҮГА, аймаг, нийслэлийн ЗДТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.</p>
	<p>ДЧУ-6: Стратегийн ач холбогдол бүхий түүхий эд, ашигт малтмалын ордын талбайн хил, заагийг тогтоох, батлуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих.</p>	<p>ЗГХЭГ, бүх яамд, АМГТГ, ҮГА, аж ахуйн нэгжүүд.</p>
	<p>ДЧУ-7: Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгаа, эрэл үнэлгээний ажил хийж хэтийн төлөвийг үнэлсэн, баялгийг нь тогтоосон газарт хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг ялгах, тэдгээрийг холбогдох журмын дагуу шийдвэрлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих.</p>	<p>ЗГХЭГ, бүх яамд, АМГТГ, ҮГА, аймаг, нийслэлийн ЗДТГ.</p>
	<p>ДЧУ-8: Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг ил тод, олон нийтийн хяналтын дор зохион байгуулах, хэрэгжилтийг хангах, хяналт тавих.</p>	<p>АМГТГ.</p>
<p>ҮЧҮ-4: Геологи, эрдэс баялгийн үндэсний гео-мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх.</p>	<p>ДЧУ-8: Геологийн салбарын нэгдсэн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөгжүүлэх, хуулиар зөвшөөрөгдсөн мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй болгох ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих.</p>	<p>ЗГХЭГ, ХЗДХЯ, ТЕГ, АЕГ, АМГТГ, ҮГА, УДТ, ХХМТГ, аж ахуйн нэгжүүд.</p>

2.2. Уул уурхайн бодлого хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж

Ерөнхий чиг үүрэг-1: Уул уурхайн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Уул уурхайн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох.	ДЧҮ-1: Уул уурхайн салбарын бодлого, хөтөлбөр, хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар, ангилал, зөвлөмжийн төсөл боловсруулах, батлуулах.	ЗГХЭГ, СЯ, ХЗДХЯ, ГХЯ, АМГТГ, ҮГА, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.
	ДЧҮ-2: Уул уурхайн салбарын бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах.	ЗГХЭГ, СЯ, ХЗДХЯ, БОАЖЯ, ЭХЯ, ЗТХЯ, МХЕГ, АМГТГ, ҮГА, ТЕГ, ГЕГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.
ҮЧҮ-2: Ашигт малтмалын олборлолт, баяжуулалтын хэмжээг нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх.	ДЧҮ-3: Ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйгээр хангах, хэрэгжилтийг зохицуулах.	СЯ, БОАЖЯ, ЭХЯ, ЗТХЯ, МХЕГ, АМГТГ, ҮГА, аймаг, нийслэлийн ЗДТГ, МУИС-ын ШУС, ШУТИС-ын ГУУС, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.
ҮЧ-3: Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх.	ДЧҮ-4: Уул уурхайн салбарын ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хэрэгжилтийг зохицуулах, байгууллагын дэргэдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороодын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах.	БОАЖЯ, СЯ, МХЕГ, ХЗДХЯ, АМГТГ, ТЕГ, салбарын холбоод, аймаг, нийслэлийн ЗДТГ, аж ахуйн нэгжүүд.
	ДЧҮ-5: Байгаль орчныг хамгаалах чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын менежментийн төлөвлөлтөд үнэлэлт дүгнэлт өгөх, хэрэгжилтийг хангуулах.	БОАЖЯ, СЯ, МХЕГ, ХЗДХЯ, АМГТГ, ТЕГ, салбарын холбоод, аймаг, нийслэлийн ЗДТГ, аж ахуйн нэгжүүд.
	ДЧҮ-6: Уул уурхайн салбарын судалгаа, шинжилгээ, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх.	АМГТГ, ҮГА, аймаг, нийслэлийн ЗДТГ, аж ахуйн нэгжүүд.

2.3. Газрын тосны бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж

Ерөнхий чиг үүрэг-1: Газрын тосны салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид

ҮЧҮ-1: Газрын тосны салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах.	ДЧҮ-1: Газрын тосны салбарын бодлого, хөтөлбөр, хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар, ангилал, зөвлөмжийн төсөл боловсруулах, батлуулах.	ЗГХЭГ, СЯ, ХЗДХЯ, ЭХЯ, ЗТХЯ, ГХЯ, АМГТГ, ҮГА, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.
	ДЧҮ-2: Газрын тосны салбарын бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийн зохицуулах, бодлогын удирдлагаар хангах.	ЗГХЭГ, СЯ, ХЗДХЯ, БОАЖЯ, ЭХЯ, ЗТХЯ, ГХЯ, АМГТГ, ҮГА, аймаг, нийслэлийн ЗДТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.
ҮЧҮ-2: Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, нөөц тогтоох, ашиглалт, олборлолтыг нэмэгдүүлэх.	ДЧҮ-3: Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх, эрлийн гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах, нөөц тогтоох.	СЯ, БОАЖЯ, ХХЕГ, АМГТГ, ҮГА, аймаг, нийслэлийн ЗДТГ, аж ахуйн нэгжүүд.
	ДЧҮ-4: Газрын тосны ашиглалт, олборлолтыг тогтвортой түвшинд хадгалах, үе шаттайгаар нэмэгдүүлэх.	СЯ, ЭХЯ, БОАЖЯ, АМГТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, аж ахуйн нэгжүүд.
ҮЧҮ-3: Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах.	ДЧҮ-5: Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг дамжуулах хоолойн хамт барьж байгуулах.	ЗГХЭГ, СЯ, БОАЖЯ, ЭХЯ, ЗТХЯ, БХБЯ, БХЯ, ЗХЖШ, АМГТГ, МХЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, "МГТБҮ" ТӨХХК.
ҮЧҮ-4: Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах.	ДЧҮ-6: Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах.	ГХЯ, АМГТГ, МХЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, аж ахуйн нэгжүүд.
	ДЧҮ-7: Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, түгээх станцын техник технологи, аюулгүй ажиллагааг хангах, хяналт тавих.	АМГТГ, МХЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, аж ахуйн нэгжүүд.

2.4. Хүнд үйлдвэрийн бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж

Ерөнхий чиг үүрэг-1: Хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Хүнд үйлдвэрийн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох,	ДЧҮ-1: Хүнд үйлдвэрийн салбарын салбарын бодлого, хөтөлбөр, хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар,	ЗГХЭГ, СЯ, ХЗДХЯ, АМГТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.

хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах.	ангилал, зөвлөмжийн төсөл боловсруулах, батлуулах.	
	ДЧҮ-2: Хүнд үйлдвэрийн салбарын бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах.	ЗГХЭГ, СЯ, ХЗДХЯ, БОАЖЯ, ЭХЯ, БХБЯ, ҮХГ, МХЕГ, АМГТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, МУИС-ын ШУС, ШУТИС-ын ХШУС, МТС, аж ахуйн нэгжүүд.
ҮЧҮ-2:Тэргүүний технологи, инновацийг нэвтрүүлэх, нутагшуулах, дамжуулах, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах замаар хүнд үйлдвэрийг хөгжүүлэх.	ДЧҮ-3: Хар ба өнгөт төмөрлөг, металл хийц, машин үйлдвэрлэл, нүүрс боловсруулах, химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх.	СЯ, БОАЖЯ, ЭХЯ, БХБЯ, ҮХГ, МХЕГ, АМГТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, МУИС-ын ШУС, ШУТИС-ын ХШУС, МТС, аж ахуйн нэгжүүд.
	ДЧҮ-4: Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулж, хөгжүүлэх.	БОАЖЯ, ЗТХЯ, ЭХЯ, БХБЯ, ХХААХҮЯ, ҮХГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, аж ахуйн нэгжүүд.

2.5. Төрийн захиргааны удирдлагын бодлого хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж

Ерөнхий чиг үүрэг-1: Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, зохицуулах, хэрэгжүүлэх.		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧ-1: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.	ДЧҮ-1: Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, аппаратын дотоод ажил болон олон нийттэй харилцах, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах.	ЗГХЭГ, бүх яамд, АМГТГ, ҮГА, аймаг, нийслэлийн ЗДТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд, олон улсын байгууллагууд.
ҮЧ-2: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэй боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах.	ДЧҮ-2: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө, боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах.	ЗГХЭГ, ХНХЯ, БСШУЯ, АМГТГ, ҮГА, ТАЗ, АТГ, салбарын холбоод, аж ахуйн нэгжүүд.
ҮЧ-3 Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн	ДЧҮ-3: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын	ҮАБЗ, ЗГХЭГ, бүх яамд, АМГТГ, ҮГА, салбарын

салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн талаар олон нийтэд сурталчлан таниулах.	хууль тогтоомж, түүнд нийцүүлэн боловсруулах бусад эрх зүйн актын төсөл боловсруулах, өргөн барихад дэмжлэг үзүүлэх.	мэргэжлийн холбоод, аймаг, нийслэлийн ЗДТГ, аж ахуйн нэгжүүд, олон улсын байгууллагууд.
	ДЧҮ-4: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль, эрх зүйн орчны давхардал хийдлийг арилгах, хяналт тавих.	ҮАБЗ, ЗГХЭГ, бүх яамдууд, АМГТГ, ҮГА, салбарын мэргэжлийн холбоод, аймаг, нийслэлийн ЗДТГ аж ахуйн нэгжүүд, олон улсын байгууллагууд.
ҮЧ-4: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх.	ДЧҮ-5: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын гэрээний талаар гадаад орон, олон улсын эрх зүй, туршлагыг судлах, санал гаргах, дэмжлэг үзүүлэх.	ЗГХЭГ, ГХЯ, АМГТГ, ҮГА, Элчин сайдын яамд, аймаг, нийслэлийн ЗДТГ, салбарын мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүд, олон улсын байгууллагууд.
ҮЧ-5: Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх.	ДЧҮ-6: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, сайдын төсвийн багцыг төлөвлөх, зохицуулах, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулж, үйлчилгээ үзүүлэх.	ЗГХЭГ, СЯ, ҮАГ, АМГТГ, ҮГА, аймаг, нийслэлийн ЗДТГ, салбарын мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүд.

2.6. Судалгаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж

Ерөнхий чиг үүрэг-1: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах, хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, бодлого, чиглэлийг тодорхойлох болон энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад бүх талын дэмжлэг үзүүлэх, зохицуулах, тайлагнах.		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧ-1: Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын бодлого, чиглэлийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын орчныг	ДЧҮ-1: Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомж, төсөл, хөтөлбөр, зөвлөмжийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх.	ЗГХЭГ, УУХҮЯ, СЯ, ХЗДХЯ, ГХЯ, АМГТГ, ҮГА, салбарын холбоод, олон улсын байгууллагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ, аж ахуйн нэгжүүд.

сайжруулах ажлыг зохион байгуулах.	ДЧУ-2: Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах.	ЗГХЭГ, УУХҮЯ, СЯ, ГХЯ, олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ төслийн нэгжүүд.
ҮЧ-2: Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, судалгаа, мэдээллээр хэрэглэгчийг хангах.	ДЧУ-3: Хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх.	УУХҮЯ, СЯ, АМГТГ, ҮГА, ҮХГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, аж ахуйн нэгжүүд.
	ДЧУ-4: Салбарын хөрөнгө оруулалт, татвар, бүтээгдэхүүний худалдаа, экспортын талаар судалгаа хийх, статистик мэдээллээр хэрэглэгчийг хангах.	УУХҮЯ, СЯ, ҮСХ, ГЕГ, ТЕГ, АМГТГ, ҮГА, салбарын холбоод, аймаг, нийслэлийн ЗДТГ, аж ахуйн нэгжүүд.

2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж

Ерөнхий чиг үүрэг-1: Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах.		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧУ-1: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж боловсруулах, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах.	ДЧУ-1: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг хангуулах, үр дүнг тайлагнах.	ЗГХЭГ, СЯ, АМГТГ, ҮГА, аймаг, нийслэлийн ЗДТГ.
		ДЧУ-2: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах.
ҮЧУ-2: УУХҮЯ, АМГТГ, ҮГА-ны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгж,	ДЧУ-3: Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн үйлчилгээг цахимжуулж, түргэн шуурхай хүргэх.	УУХҮЯ, АМГТГ, ҮГА.

иргэдэд чиглэсэн үйлчилгээний чанар, сайжруулах.	ДЧҮ-4: “Эрдэс баялгийн цахим засаглал” хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах.	УУХҮЯ, АМГТГ, ҮГА.
--	--	--------------------

3. АЛСЫН ХАРАА

ЭРДЭС БАЯЛГААР НИЙГМИЙН ҮНЭТ ЗҮЙЛ БҮТЭЭНЭ.

4. ЭРХЭМ ЗОРИЛГО

ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ, НЭМҮҮ ӨРТӨГ ШИНГЭСЭН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЖ, ЭРДЭС БАЯЛГИЙН САН ХӨМРӨГИЙГ АРВИЖУУЛАХ ЗАМААР ТОГТВОРТОЙ, ОЛОН ТУЛГУУРТ ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЦИЙГ БИЙ БОЛГОЖ, БАЯЛГИЙН ШУДАРГА ХУВААРИЛАЛТЫН ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ОРШИНО.

5. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

2.1. Геологийн салбар

Монгол Улсын хэмжээнд нийт нутаг дэвсгэрийн 41.06 хувь нь 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд хамрагдсан бол агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлаар 60 хувь, Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх ажлаар 30 хувь, геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлаар 65 хувийг тус тус хамруулсан.

Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд 85 төрлийн ашигт малтмалын 2,500 орчим орд, 10 мянга гаруй илрэл тэмдэглэгдсэн. Үүнээс голлох 10 ашигт малтмалын нөөцийг задлан харуулвал: нүүрс 33.4 тэрбум.тн, төмрийн хүдэр 1.84 тэрбум.тн, зэс 69.9 сая.тн, цайр 4.4 сая.тн, гянтболд 692.21 мянган.тн, алт 448.1 тн, мөнгө 34.5 тн, уран 166.65 мянга.тн, хайлуур жонш 34.2 сая.тн, газрын тос 332.3 сая.тн тус тус бүртгэгдээд байна.

2021 оны I улирлын байдлаар нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд 6.1 сая.га талбайд 2,610 тусгай зөвшөөрөл олгогдсон бөгөөд үүний 1.6 сая.га талбайд 1,698 ашиглалтын тусгай зөвшөөрөл, 4.4 сая.га талбайд 912 хайгуулын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Хайгуул тусгай зөвшөөрөл нийт газар нутгийн 2.8 хувийг эзэлж байгаа бол ашиглалтын тусгай зөвшөөрөл 1.1 хувийг тус тус эзэлж байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн 31.4 хувийг алт, 17.8 хувийг нүүрс, 15.4 хувийг барилгын материал, түгээмэл тархацтай ашигт малтмал, 11.7 хувийг хайлуур жонш, 4.5 хувийг төмрийн хүдэр, 19.2 хувийг бусад ашигт малтмал эзэлж байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг хөрөнгө оруулагч улсаар нь ангилж үзвэл 75.3 хувийг дотоодын хөрөнгө оруулагч, 19.8 хувийг гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд, 4.9 хувийг хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд тус тус эзэлж байна.

Тус салбарт 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 3,320 хүн ажиллаж байна.

Геологийн салбарт тулгамдаж буй дараах асуудлууд байна. Үүнд:

1. Монгол Улсын геологийн салбарын эрх зүйн орчны хөгжил 1990 оноос хойш үндсэндээ зогсонги байдалд орж, геологийн судалгаатай холбоотой харилцаа тодорхой төрлийн ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалтын хүрээнд салбар, тусгай хуулиудаар зохицуулах чиг хандлага давамгайлж, суурь хууль болох Газрын хэвлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хоорондын уялдаа холбоо суларсан. Тодруулбал, 1992 онд Газрын тосны тухай хууль, 1994 онд Ашигт малтмалын тухай хууль, 1995 онд Усны тухай хууль гэх мэт салбар хуулиудыг батлахдаа Газрын хэвлийн тухай хуульд газрын хэвлий дэх геологийн судалгааны асуудлыг цогцоор нь геологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамааруулах, газрын хэвлийн судалгаа, удирдлага нэгдмэл байх зарчмыг зөрчин Газрын хэвлийн тухай хуульд шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулалгүй орхигдуулж байсан нь төрөөс геологийн салбарт баримтлах бодлогын эрх зүйн орчны цогц байдлыг алдагдуулсан;

2. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй геологийн судалгааны ажилд зарцуулах төсвийг тогтвортой нэмэгдүүлэх талаар төрийн бодлогод тусгагдсаны дагуу УИХ-аас нэмэгдүүлэн баталдаг хэдий ч санхүүжилт цаг хугацаандаа хийгдэхгүй байгаа нь тухайн төсөл, арга хэмжээний чанарт сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн, Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологи, судалгааны ажлын гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж байгаа нь боломжгүй, зарим тохиолдолд геологи, эрдэс баялгийн нэгдсэн сан, нөөцийн нэгдсэн бүртгэл гэх мэт өндөр ач холбогдол бүхий албаны нууцад хамаарах мэдээлэлтэй хуулийн этгээд шууд харилцах боломжийг бүрдүүлсэн;

3. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгохыг хориглох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарсантай холбоотойгоор хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо 2010 оноос эхлэн буурч, өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоог давсан үзүүлэлттэй байна. Тухайлбал, хүчин төгөлдөр хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь хэмжээ 2012 онд 12.9 хувь байсан бол 2021 оны I улирлын байдлаар 3.9 хувь болж 69.7 хувиар буурсан. Хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо ийнхүү эрс буурч байгаа нь ашигт малтмалын нөөцийг өсгөх, шинээр томоохон орд илрүүлэх боломжийг бууруулж байна;

4. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг зөвхөн сонгон шалгаруулалтын журмаар олгохоор хуульчилсан нь хөрөнгө оруулагчдыг сонирхсон ашигт малтмалын чиглэлээр хайгуулын үйл ажиллагаа явуулах боломжгүй болгосон;

5. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа геологийн суурь судалгааны ажил болон хууль, тогтоомжийн хүрээнд хайгуул, олборлолт явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зарим орон нутгийн удирдлага, иргэд, төрийн бус байгууллагын зүгээс хууль, тогтоомжид заагаагүй үндэслэлээр эсэргүүцэх, зогсоох болсон нь хайгуулын ажил гүйцэтгэхэд хүндрэл учруулж байгаа зэрэг болно.

2.2. Уул уурхайн салбар

Уул уурхайн салбар нь 2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-ний 22 хувь, төсвийн орлогын 24.3 хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 71 хувь, экспортын 93 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 72.5 хувийг тус тус бүрдүүлсэн.

Улсын хэмжээнд 40.5 сая тн нүүрс, 1,276.7 мян.тн зэсийн баяжмал, 20.2 тн алт, 6,038.3 тн молибдений баяжмал, 127.3 мян.тн хайлуур жоншны хүдэр, 85.0 мян.тн хайлуур жоншны баяжмал, 9,224.4 мян.тн төмрийн хүдэр, 4,716.4 мян.тн төмрийн хүдрийн баяжмал, 76.3 мян.тн цайрын баяжмал тус тус үйлдвэрлэсэн байна.

2020 онд нийт 250 уурхай, үйлдвэрийн газар үйл ажиллагаа явуулсан. Үүнээс алтны шороон ордын 92, алтны үндсэн ордын 9, нүүрсний 58, хайлуур жоншны 34, төмрийн 18, бусад төрлийн ашигт малтмалын 39 уурхай, үйлдвэр ажиллажээ. Баяжуулах үйлдвэрийн хувьд төмрийн 18, алтны үндсэн ордын 9, хайлуур жоншны 7, нүүрсний 5, холимог металлын 5, бусад төрлийн ашигт малтмалын 12 үйлдвэр тус тус ажилласан байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт 2020 онд 7.1 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 237.8 сая ам.доллараар буюу 3.5 хувиар буурсан бөгөөд нийт экспортын бүтээгдэхүүний 90 гаруй хувийг БНХАУ-д гаргаж байна.

Зэс болон нүүрсний экспорт нь дангаар уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспортын нийт дүнгийн 55 хувь болж байгаа бөгөөд компаниар нь авч үзвэл, Эрдэнэт үйлдвэр 642.17 мян.тн зэсийн баяжмал, "Оюутолгой" ХХК 752.88 мян.тн экспортолсон бол "Эрдэнэс-Тавантолгой" ХК 12.19 сая.тн, "Энержи Ресурс" ХХК 3.66 сая.тн, "Монголын алт" ХХК 3.43 сая.тн нүүрс тус тус экспортолсон.

Тус салбарт 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 51.9 мянган хүн ажиллаж байгаагын 3 хувийг гадаадын мэргэжилтэн эзэлж байна.

Уул уурхайн салбарт тулгамдаж буй дараах асуудлууд байна. Үүнд:

1. Монгол Улсын хэмжээнд 21 аймгийн дийлэнх хэсэгт нь ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа явагдаж байгаа хэдий ч салбарын яамны хувьд орон

нутагт уул уурхайн асуудал хариуцсан биеэ даасан нэгж байдаггүйгээс салбарын бодлого, шийдвэр хэрэгжилтийн шатанд зөрчил, хийдэл үүсдэг;

2. Ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын хувьд нэг зах зээлээс хэт хамааралтай, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин доогуур, эрх зүйн зохицуулалтгүй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүд бий болсон, дэд бүтцийн хүрэлцээ муу байгаа нь салбарын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна;

3. Ашигт малтмалын бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчдэд хүргэж чадалгүй дамжуулан борлуулагч нарт худалдаалдаг, мөн түүнчлэн аж ахуйн нэгжүүд үнэ шилжилтийн аргыг ашиглаж байгаа зэрэг шалтгаанаар уул уурхайгаас хангалттай хэмжээнд ашиг хүртэж чадахгүй байгаа;

4. Томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай хэдий ч уул уурхайн томоохон төслүүдэд олгож буй санхүүгийн дэмжлэг болон зээлийн хүрэлцээ муу;

5. Иргэдийн зүгээс уул уурхайн салбарын талаарх ойлголт дутмаг, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын зүгээс салбарын эсрэг сөрөг сурталчилгаа явуулдаг, мөн түүнчлэн хууль бус ашигт малтмал олборлолт зэргээс үүдэн салбарын нэр хүнд муудаж байна. Мөн түүнчлэн уул уурхайгаас олж буй орлогыг оновчтой хуваарилах, ашиглах тогтолцоо бүрдээгүй байгаагаас хөгжлийн зорилтуудыг санхүүжүүлж чадахгүй байгаа зэрэг болно.

2.3. Газрын тосны салбар

Монгол улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт 18 талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа, 5 талбайд уламжлалт бус газрын тос метан хийн хайгуулын үйл ажиллагаа, 3 талбайд газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

Хөрөнгө оруулагч, гэрээлэгч компаниудын харьяаллыг авч үзвэл, Монгол улсын 7 компани 9 талбайд, БНХАУ-ын 9 компани 11 талбайд, бусад /Канад, Австрали, Кэйманы арал, Мэны арал/ улсын харьяалалтай 5 компани 6 талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж байна.

Газрын тосны эрэл, хайгуулын ажлын үр дүнд “Тосон-Уул XIX”, “Тамсаг-XXI”, “БХГ-97” талбайд нөөц тогтоосон бөгөөд газрын тосны нөөцийг “баталгаат” зэрэглэлээр нийт 332.64 сая тонн, “ашиглалтын баталгаат” зэрэглэлээр нийт 43.26 сая тонноор тус тус Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэгдсэн. Эдгээр талбайгаас 2019 онд нийт 887.8 мян.тн газрын тосыг олборлон БНХАУ-д экспортолж байсан бол “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр 2020 онд 554.0 мян.тн болж буурсан.

Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний худалдаа эрхлэх, жижиглэнгийн худалдаа эрхлэх чиглэлээр 149 аж ахуйн нэгж үйл ажиллагаа

явуулж байгаа бөгөөд 2020 онд нийт 1,945 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон байна.

Шатахууны импортын хэмжээг бүтцээр нь авч үзвэл, А-80 автобензиний хэрэглээ тогтмол буурч байгаа бол АИ-92 болон АИ-95 автобензиний импорт тогтмол өсч, харин дизелийн түлшний импортын хэмжээ нь уул уурхай, олборлолтын үйл ажиллагаатай уялдан хэлбэлзэж байна.

Засгийн газрын 2017 оны 92 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг хэрэгжүүлэх шийдвэр гарсантай холбоотойгоор Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт 1,500 мян.тн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр барьж байгуулахаар ажиллаж байна. Тус үйлдвэр ашиглалтад орсноор дотоодын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээний 55 хувийг хангахаар тооцсон.

Салбарын хэмжээнд 1995-2020 оны хооронд газрын тосны төрөл бүрийн мэргэжлээр 1210 бакалавр, 100 гаруй магистр, 5 доктор, нийт 1032 мэргэжилтэн бэлтгэснээс зөвлөх 52, мэргэшсэн 84 нийт 136 мэргэшсэн мэргэжилтэн байна.

Газрын тосны салбарт тулгамдаж буй дараах асуудлууд байна. Үүнд:

1. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь Тосон-Уул, Тамсагийн ордуудын “Ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г анх 2012 онд хүлээлгэн өгсөн ба сүүлийн 5 жилийн түүхий тосны зах зээлийн үнийн уналтаас хамааран тус төлөвлөгөөний дагуу ордыг эдийн засгийн үр ашигтай ашиглах боломжгүй болж байна. Тодруулбал, төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2020 он гэхэд дээрх 2 ордоос олборлох тосны хэмжээ 1.5 сая.тн-д хүрэх ёстой хэдий ч бодит байдал дээр 1.0 сая.тн-д хүрэхгүй байна. Иймд, цооногийн өрөмдлөг, шингэн хагалбар, цооногийг олборлолтын тоног төхөөрөмжөөр тоноглох, ус шахалтын хэмжээг нэмэгдүүлэх зэрэг нэмэлт ажлуудыг хийхгүй тохиолдолд дээрх 2 ордоос олборлох түүхий тосны хэмжээ улам багасах;

2. Газрын тосны олборлолтын үйл ажиллагаанд шаардлагатай цахилгаан эрчим хүчний дутагдлаас үүдэн “Тосон-Уул XIX” болон “Тамсаг XXI” талбайнууд дахь 100 гаруй цооногийн олборлолтыг зогсоож, хоногт 240 тн тос дутуу олборлож байгаа бөгөөд өвлийн улиралд 5-6 МВт-ын цахилгаан эрчим хүчний дутагдал үүсч, сар бүр 12,000 тн тос дутуу олборлохоор байгаа нь олборлолтын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх;

3. Орон нутгийн шийдвэр, нутгийн иргэдийн эсэргүүцэл болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанаас шалтгаалж түүхий тосны тээвэрлэлт саатах, зогсох асуудал нэмэгдэж байна. Тухайлбал, Дорнод аймгийн Засаг даргын шийдвэрээр “Тосон-Уул XIX”, “Тамсаг XXI” талбайнуудын түүхий тосны тээвэрлэлтийн үйл ажиллагааг 1 сар зогсоож байсан бол “Машинтай жагсаал” ТББ болон “Нутгаа аврах Чойбалсанчууд” НҮТББ тавьсан шаардлага, эсэргүүцлээс үүдэн экспорт 2020 онд мөн зогссон;

4. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах тос дамжуулах хоолойн санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байгаа тул уг асуудлыг яаралтай шийдвэрлэж, үйлдвэр ашиглалтад орохоос өмнө барьж байгуулах зэрэг болно.

2.4. Хүнд үйлдвэрийн салбар

2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр боловсруулах үйлдвэрлэлийн салбар нь аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 21.3 хувийг бүрдүүлж байна.

Хүнд үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг 2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр тооцвол 553.4 мян.тн нүүрсэн шахмал түлш, 9.5 мян.тн катодын зэс, 15.3 мян.тн металл бэлдэц, 16.6 мян.тн металл цувимал, 5.2 сая тн ган төмөр хийц, 74.3 тн цахилгааны утас тус тус үйлдвэрлэсэн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүний 11.7 их наяд төгрөг буюу 59.5 хувийг гадаад зах зээлд борлуулсан.

Өнөөгийн байдлаар хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр 86 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд ган туйван, ган бөмбөлөг, катодын зэс, зэс утас, резин, газрын тосны бүтээгдэхүүн, металлургийн кокс, тээврийн хэрэгсэл угсрах болон металл хийцийн үйлдвэрүүд ажиллаж байна.

Аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын 40.5 хувь нь боловсруулах үйлдвэрийн салбарт ажиллаж байгаагаас 5,122 хүн хүнд үйлдвэрийн салбарт ажиллаж байна.

Хүнд үйлдвэрийн салбарт тулгамдаж буй дараах асуудлууд байна. Үүнд:

1. Хүнд үйлдвэрийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд зардал өндөр, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа харьцангуй урт тул тус салбарт хувийн хөрөнгө оруулалтыг татах, гадаадын хөнгөлөлттэй зээлд хамааруулах боломжийг бүрдүүлэх үүднээс Засгийн газраас баталгаа гаргах, дотоодын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр дэмжих шаардлагатай;

2. Одоо ажиллаж буй үйлдвэрүүдийн хүчин чадлын ашиглалт хангалтгүй, дотоодын зах зээлийг хамгаалах, дэмпингийн чанартай импортын эсрэг зохицуулалтын механизм бий болоогүй;

3. Дэвшилтэд технологи, инноваци нэвтрүүлэх боломж хомс, хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспортын тээвэр, ложистикийн дэд бүтцийн сүлжээ хангалттай хөгжөөгүй;

4. Экспортод чиглэсэн, өрсөлдөх чадвартай бараа, бүтээгдэхүүнийг худалдааны бодлогоор дэмжин гадаад зах зээлд нэвтрүүлэх механизм бүрдээгүй;

5. Инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчид бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх болон үйлдвэрлэл эрхлэгчдэд удирдлагын дадлага, ур чадвар

эзэмшүүлэх тогтолцоог бий болгох, бэжжүүлэх замаар үйлдвэрлэл явуулахад шаардагдах хүний нөөцийг бүрдүүлэх асуудал тулгарч байна. Тухайлбал, хүнд үйлдвэрийн чиглэлээр хэрэгжих томоохон төслүүд хэрэгжиж эхэлснээр 100 гаруй мэргэжлийн нийт 2,747 шууд ажлын байр нэмэгдэх ба үүний 35 хувь буюу 960 ажлын байранд тусгай дунд боловсролтой ажилтан шаардлагатай.

2.5. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль, эрх зүйн орчин

Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын бодлого, үйл ажиллагааг зохицуулсан 50 орчим хууль өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа бол Засгийн газар болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад эрх олгосон зохицуулалтын хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон 49 акт батлагдаж, Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн.

Салбарын эрх зүйн зохицуулалт нь 1992 оны Үндсэн хуульд тулгуурлаж байгаа бөгөөд 1988 онд батлагдсан Газрын хэвлийн тухай хууль болон Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтууд нь газрын хэвлийн баялгийн өмчлөл, ашиглалтын талаар баримтлах үндсэн зарчим болж байна.

Түүнчлэн УИХ-ын 2014 оны 18 дугаар тогтоолоор “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”, Засгийн газрын 2018 оны 169 дүгээр тогтоолоор “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2019 оны 214 дүгээр тогтоолоор “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр” зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүд батлагдан хэрэгжиж байна.

Салбарын хууль, эрх зүйн орчинг сайжруулах, хууль хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор эрдэс баялгийн салбарт үйлчилж буй голлох 10 хуульд дүн шинжилгээ хийж, нийт 267 давхардал, 150 зөрчил, 150 хийдэлийг тогтоосон.

Цаашид салбарын хууль, эрх зүйн харилцаанд цаг үеийн шаардлагаар үүссэн харилцааг хуулиар зохицуулах, нэмэлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, хүчингүй болсонд тооцох зэрэг шийдвэрлэх шаардлагатай дараах асуудлууд тулгарч байна. Үүнд:

1. Ашигт малтмалын тухай хуульд 2006 оноос хойш нийт 34 удаа нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан тус хуулийг шинэчлэн боловсруулах зайлшгүй шаардлага тулгарч байна. Энэ хүрээнд хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглахад тавигдах ерөнхий шаардлага, хайгуул ашиглалтын тусгай зөвшөөрөл болон техник, эдийн засгийн үндэслэлтэй холбоотой харилцаа, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах болон мэдээ, тайлан гаргах үүрэг, уурхайн хаалт, тусгай зөвшөөрөл цуцлах болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой харилцаа зэрэг зохицуулалтыг боловсронгуй болгох, захиргааны хэм хэмжээ тогтоосон зарим актыг шинэчлэх;

2. Газрын тостой холбогдсон зарим хуулиудын хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, газрын тосны эрлийн гэрээний загварыг батлах, эрэл хийх гэрээ байгуулах зохицуулалтыг боловсронгуй болгох, газрын тосны төрийн өмчит компани байгуулахтай холбогдуулан эрх, үүргийг тодорхойлох, шатдаг хий, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, чанарын хяналт тавих, зохицуулалтын механизмыг бий болгох, газрын тосны эрэл, хайгуулын ажлын үр дүнгийн болон нөөцийн тооцооны тайлан, орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд дүгнэлт өгөх зохицуулалтыг нарийвчлах, газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох болон хуулийн зарим нэр томъёо, тодорхойлолтыг шинээр нэмж тусгах;

3. Хүнд үйлдвэрийн салбарт өндөр бүтээмжтэй, байгаль орчинд ээлтэй техник, технологи нэвтрүүлэх, инженер, техник ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг шинэчлэх, хүнд үйлдвэрийн салбарын бараа, бүтээгдэхүүний гадаад зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор Хүнд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах болон Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;

4. Салбарын төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага хоорондын удирдлага, зохион байгуулалт, чиг үүргийг нарийвчлан тодорхойлох, чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгох зэрэг болно.

2.6. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын орчин

Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалттай холбоотой харилцаа нь 2013 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулагдаж байна. Уг хуулиар аливаа хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхээр заасан байдаг бөгөөд хуульд заасан шалгуурыг хангасан хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ болон байршлаас хамаарч хөрөнгө оруулалтын тогтворжуулах гэрчилгээг олгож байна.

Үүнээс уул уурхай, хүнд үйлдвэр болон дэд бүтцийн салбарт 5-18 жилийн хугацаатай тогтворжуулах гэрчилгээ олгож байгаа бөгөөд ийнхүү олгохдоо аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг тогтворжуулж байна. Өнөөгийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 16 компанид тогтворжуулах гэрчилгээ олгогдоод байгаагын 4 нь уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын компани байна.

Мөн түүнчлэн тус хуулийн 20.1-д заасны дагуу 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагч нь Засгийн газартай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах боломжтой бөгөөд Монгол Улсын өнөөдрийн байдлаар хэмжээнд хөрөнгө оруулалтын 6 гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байгаагын 3 нь уул уурхай, хүнд үйлдвэрийн салбартай холбогдож байна.

Монгол Улс нь “Улс болон гадаад улсын иргэний хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенц” (1965)-д нэгдэн орсон бөгөөд 43 улстай Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр, 26 улстай Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээрийг тус тус байгуулсан байдаг нь геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулж буй гадаадын хөрөнгө оруулагчдад таатай хууль эрхзүйн орчин болно.

Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалтын дийлэнх нь ГШХО хэлбэрээр уул уурхайн салбарт хийгдэж байна.

2010-2020 оны хооронд уул уурхайн салбарт нийт 17.7 тэрбум ам.долларын ГШХО орсон бол үүнээс 2011 онд хамгийн өндөр буюу 4.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт орсон нь тухайн үед хийгдсэн нийт хөрөнгө оруулалтын 78 хувьтай тэнцэж байсан. Дээрх хугацаанд хийгдсэн ГШХО-ын 38 хувь буюу 9.17 тэрбум ам.доллар нь Канадаас, 21.3 хувь буюу 5.16 тэрбум ам.доллар нь БНХАУ-аас, 6.5 хувь буюу 1.56 тэрбум ам.доллар нь Сингапураас, 6.2 хувь буюу 1.49 тэрбум ам.доллар нь Люксембургийн Вант Улсаас тус тус хийгдсэн байна. 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.68 тэрбум ам.долларт хүрсэн нь мөн оны өмнөх үетэй харьцуулахад 41.4 хувиар буурсан үзүүлэлт юм.

Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалттай холбоотой тулгамдаж буй дараах асуудлууд байна. Үүнд:

1. Салбарын хөрөнгө оруулалт нь хэлбэлзэл ихтэй, тогтворгүй бөгөөд бүтцийн хувьд байгалийн нөөц, баялаг эрэлхийлсэн хөрөнгө оруулалтын хэлбэр хэт давуу байна. Тухайлбал, 2010-2014 оны хооронд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт +262 хувиас -70 хувийн хооронд хэлбэлзсэн. Түүнчлэн ашигт малтмалын нөөц, баялаг эрэлхийлсэн ГШХО нь 2012 оноос хойш хийгдсэн нийт хөрөнгө оруулалтын 81 хувийг эзэлж байна.

2. Салбарын хөрөнгө оруулалт нь ашигт малтмалын зах зээлийн үнэ болон эрэлтээс өндөр хамааралтай байдаг бөгөөд зах зээлийн гэнэтийн өөрчлөлт нь дотоодын макро эдийн засгийн тогтвортой байдалд нөлөөлж байдаг. Тухайлбал, 2010-2011 онуудад уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарыг чиглэсэн хөрөнгө оруулалтын урсгал нь төлбөрийн тэнцэлд нөлөөлж, 2012 онд урсгал тэнцлийн алдагдал нь ДНБ-ний 27 хувьтай тэнцэх хэмжээнд хүрч байсан.

3. Хууль эрх зүйн орчны гэнэтийн өөрчлөлт, улс төрийн шийдвэрээс шалтгаалан салбарт хийгдэж буй ГШХО огцом буурах, хөрөнгө оруулагчдын итгэлийг алдах, улмаар Монгол Улсаас хөрөнгөө татахад хүргэдэг. Тухайлбал, 2006 онд батлагдсан “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай” хууль, 2012 онд батлагдсан “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хууль нь геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад үлэмж сөргөөр нөлөөлсөн.

4. Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах чиглэлд бодлого, хөтөлбөрүүд хангалттай батлагдсан боловч хөрөнгө оруулалтыг хамгаалах, нэмэгдүүлэх болон худалдааг дэмжих бодлого хангалтгүй байна. Уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо, хэмжээ хэдийгээр өсч байгаа ч нэр, төрөл цөөн, технологийн агууламж бага, голдуу хагас боловсруулсан бүтээгдэхүүн хэлбэрээр экспортод гарч байгаа бөгөөд санхүүжилт болон борлуулалтыг дэмжих дэд бүтэц хангалтгүй тул уул уурхай, хүнд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниуд эргэлтийн хөрөнгө дутагдалтай, шинэ техник, технологи нэвтрүүлэх боломж хомс, импортын бараатай өрсөлдөх, үйлдвэрлэл хөгжих боломж нөхцөл хязгаарлагдмал байгаа зэрэг тус тус болно.

2.7.Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хүний нөөц

Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбар нь бүтээмж өндөр, хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах хүчний эрэлт ихтэй салбар юм.

Уул уурхайн хөгжлийг даган ашигт малтмалын олборлолт явагдаж буй бүс нутаг руу чиглэсэн хүн амын урсгал нэмэгдэж байгаа нь салбар хоорондын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнийг бий болгож байна. Үүний үр дүнд ур чадвартай ажлын байр уул уурхайн салбарт түлхүү нэмэгдэх болсон.

2019 оны жилийн эцсийн байдлаар уул уурхайн салбарын хөдөлмөрийн бүтээмж улсын дунджаас 4 дахин их байгаа нь бусад салбартай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын дундаж цалин 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар уул уурхайн салбарт мөн адил хамгийн өндөр буюу 3.29 сая.төгрөг байгаа нь улсын дунджаас 2.4 дахин их үзүүлэлт юм.

Уул уурхайн салбар 2020 оны 2 дугаар улиралд хамгийн их буюу 55,135 ажлын байр бий болгосноос 81 хувь нь эрэгтэй ажиллагсад, 19 хувийг эмэгтэй ажиллагсад бүрдүүлж, хүйсийн харьцаа 4:1 байна. Салбарын хэмжээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/114 дүгээр тушаалаар “Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жөндөрийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг батлагдан хэрэгжиж байна.

Ашигт малтмалын олборлолт, баяжуулалт, боловсруулалттай холбогдсон үйл ажиллагаа нь нарийн мэргэжил, мэргэшил шаарддаг учир дотоодоос ажиллах хүчээр бүрэн хангахад хүндрэлтэй байдаг. Иймд, ялангуяа уурхайн бүтээн байгуулалтын үед гадаадаас цөөнгүй ажиллах хүчийг квотоор ажиллуулдаг.

Цаашид салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд дараах асуудал тулгарч байна. Үүнд:

1. Салбарын ажиллах хүчний мэдлэг, чадвар өнөөгийн техник технологийн шаардлагад тэр бүр нийцэхгүй байна. Дэвшилтэд техник технологи, нарийн мэргэжлийн ажиллах хүчин нь эрдэс баялгийн салбарын урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах үндсэн нөхцөлийн нэг тул салбарын ажиллах хүчийг ирээдүйд бий болох технологийн дэвшил, мэргэжил, ур чадварт тулгуурлан бэлтгэх;

2. Эрдэс баялгийн салбарын тогтвортой үйл ажиллагаа нь ашигт малтмалын зах зээлийн үнэ ханшны өөрчлөлт, хөрөнгө оруулалт, төрөөс баримтлах бодлого, шийдвэрээс өндөр хамааралтай байдаг тул салбарын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн байдал тогтворгүй байна;

3. Салбарын хэмжээнд залуу, мэргэжлийн өндөр ур чадвартай ажиллах хүчин бэлтгэгдэн гарч байгаа хэдий ч хөдөлмөрийн зах зээлийн болон капиталын оновчгүй хуваарилалтаас үүдэн бүтээмжийн өсөлт сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна;

4. Салбарын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан хөдөлмөрийн нөхцөл хүнд, ажлын байрны осол, гэмтэл их гардаг тул геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, журмыг боловсронгуй болгох зэрэг тус тус болно.

Байгууллагын SWOT шинжилгээ

	Давуу тал	Сул тал
Дотоод	<ul style="list-style-type: none"> - Төсвөөс санхүүждэг; - Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудал нь өргөн хүрээг хамардаг; - Ажиллах орчин, нөхцөл бүрдсэн; - Байгууллагын дотоод үйл ажиллагааны журам, заавар, албан хэрэг хөтлөлт сайн, сүлжээний програм хангамжийг нэвтрүүлсэн; - Мэргэшсэн боловсон хүчин сайтай; - Үйлчилгээний чанар, хэрэглэгчийн сэтгэл ханамжид илүү анхаардаг. 	<ul style="list-style-type: none"> - Стратеги, төлөвлөлт хангалтгүй; - Салбарын хөгжлийг дэмжих хууль, эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй; - Байгууллагын дотоод нэгжүүдийн уялдаа холбоо, мэдээлэл солилцох байдал хангалтгүй; - Орон нутагт харьяа нэгж, салбар байхгүй; - Алба хаагчдын ажил үүргийн хуваарь жигд бус; - Алба хаагчдын албан тушаал дэвших, албан тушаалын ангилал зэрэглэл, зэрэг дэв ахиулах асуудал нээлттэй биш; - Албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр байхгүй; - Төрийн алба хаагчийн мэргэшсэн, тогтвортой байх зарчмын хэрэгжилт сул.
	Боломж	Эрсдэл

Гадаад	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын бодлого, үйл ажиллагааны нийгмийн хүлээлт өндөр; - Эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл их; - Зах зээлийн таатай үе ирж байгаа; - Гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх; - Боловсон хүчнийг бэлтгэх, дахин сургах. 	<ul style="list-style-type: none"> - Улс төрийн тогтворгүй байдал нь байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх; - Гадаад болон дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр төсөл хөтөлбөрийн хэрэгжилт удаашрах, зогсох; - Албан хаагчид авилга, албан тушаалын хэрэгт холбогдох; - Салбарт гарсан аливаа алдаанаас үүдэн байгууллагын нэр хүнд унах.
--------	--	--

Байгууллагын SWOT шинжилгээний үр дүнд тулгуурлан УУХҮЯ нь дараах стратегийг баримтлан ажиллана. Үүнд:

1. Салбарын давуу талд тулгуурлан гадаад орчны таатай боломжийг ашиглах стратеги:

Байгууллагын менежментийг сайжруулах, иргэдэд мэдээллийг ил тод, хүртээмжтэй хүргэх, гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, албан хаагчдын мэдлэг, чадвараа дээшлүүлэх боломжийг дэмжих, томоохон төсөл, хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт татах.

2. Салбарын гадаад орчны таатай боломжийг ашиглан сул талыг сайжруулах стратеги:

Байгууллагын үйл ажиллагаанд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, байгууллагын бодлого, үйл ажиллагааны стратеги, төлөвлөлтийг боловсронгуй болгох, нэгжүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулах, төсөл, хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах, орон нутагт яамны харьяа нэгж байгуулах, цахим засаглалыг байгууллагын хэмжээнд хөгжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөцийг системтэй бэлтгэх.

3. Салбарын давуу талд тулгуурлан гадаад орчны эрсдэлийг даван туулах стратеги:

Салбарын нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон албан хаагчдын ёс зүйн дүрмийг боловсронгуй болгох, байгууллагын албан хаагчдийг авилга, албан тушаалын хэргээс ангид байлгах.

4. Салбарын гадаад орчны эрсдэлтэй нөхцөлд сул талаа сайжруулах замаар сөрөг үр дагаврыг бууруулах стратеги:

Томоохон төслийг хэрэгжүүлэхэд хамтын ажиллагааны оновчтой механизмыг бүрдүүлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрийн албан хаагчдын

тогтвортой ажиллах боломжийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар байгууллагын нэр хүндийг өсгөх.

6. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Орчны шинжилгээний үр дүнд суурилан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь 2020-2024 онд дараах стратегийн зорилгуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Геологи-хайгуулын ажлыг нэмэгдүүлж, ашигт малтмалын нөөц, баялгийн хэмжээг өсгөн олборлох салбарыг эрдсийн түүхий эдээр тогтвортой хангах;

2. Уул уурхайн салбарын ДНБ-нд эзлэх хувийг 30 хүртэл хувьд хүргэж, эдийн засгийн өсөлтийг хангах;

3. Газрын тосны бүтээгдэхүүний импортын хамаарлыг 55 хүртэл хувиар бууруулж, бүтээгдэхүүн хангамжийн тогтвортой байдлыг хангах;

4. Боловсруулах үйлдвэрийн ДНБ-нд эзлэх хувийг 10 хүртэл хувьд хүргэж, ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх;

5. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулж, баялгийн засаглалын сайн туршлагыг нэвтрүүлэх;

6. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын орчинг сайжруулж, уул уурхай, олборлолтын гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт хөрөнгө оруулалтад эзлэх хэмжээг 70-аас дээш хувьд хадгалах;

7. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх;

8. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааг цахимжуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх тус тус болно.

7. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны стратеги төлөвлөгөө нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө (2020-2024)-нд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэнэ.


Ингэхдээ холбогдох яамд, засгийн газрын хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагууд, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагууд, салбарын аж

ахуй нэгжүүд, төрийн бус байгууллага, иргэд болон олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагуудтай нягт уялдаа, холбоотой ажиллана.



Төлөвлөгөөг баталсан:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
(албан тушаал)
Тэмдэг




/Г.Ёндон/

(огноо)

Төлөвлөгөө боловсруулсан:

Төрийн нарийн бичгийн дарга
(албан тушаал)
Тэмдэг



/Г. Нандинжаргал/

(огноо)

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

(2020-2024 ОН)

Алсын хараа-2050 ^о Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр /сая төгрөг/
---	---------------------	------------------	--------------	-----------------	-----------------------------------

хэмжээний төлөвлөгөө, Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө (2020- 2024)					
1. Ерөнхий чиг үүргийн нэр: Геологийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.					
Үндсэн чиг үүрэг-1: Геологийн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих, бодлогын удирдлагаар хангах.					
Зорилт-1: Геологийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах.	1.1. Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв
	1.2. Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв
	1.3. Үндсэн хууль болон бусад хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан геологийн салбарт мөрдөгдөж байгаа зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	3	Улсын төсөв
	1.4. Геологийн салбарт мөрдөх дүрэм, журам, заавар, ангилал, норм норматив, аргачилсан	Батлагдсан эрх зүйн актын тоо	8	25	Улсын төсөв

	зөвлөмж, мэргэжлийн нэр, индексийг боловсруулан батлуулах.				
Зорилт-2: Геологийн шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хөгжлийн урт хугацааны бодлого, хууль тогтоомжийн төслийн судалгаа хийх, хэрэгжилтийг хангах, салбарын үйл ажиллагааг нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах.	2.1. Салбарт баримтлах бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, цаашид улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний санал, салбарт баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах.	Санал боловсруулах ажлын хувь	0	100	Улсын төсөв
	2.2. Салбарын хууль, эрх зүйн баримт бичгүүдэд зөрчил, давхардал, хийдэл, эрэлт хэрэгцээ, шаардлагын судалгаа хийх, судалгааны дүгнэлтэд үндэслэн салбарт шаардлагатай хууль тогтоомжийг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах.	Санал боловсруулах ажлын хувь	0	100	Улсын төсөв
	2.3. Салбарын болон холбогдох бусад чиглэлийн бодлого, хөтөлбөр, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах.	Хэрэгжилтийн хувь	0	100	Улсын төсөв
	2.4. Орон нутгийн удирдлага, иргэдтэй болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, геологийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, геологичдын дунд чуулга уулзалт	Хэрэгжилтийн хувь	0	100	Улсын төсөв, хувийн хөрөнгө оруулалт

	зохион байгуулах, салбарын үйл ажиллагааг сурталчлан таниулах.				
Үндсэн чиг үүрэг-2: Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлж, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах.					
Зорилт-3: Бүх төрлийн геологийн судалгааны ажлыг төлөвлөх, төсвийн саналыг боловсруулах, нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг тодорхойлох, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих.	3.1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.	Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь	41%	47%	Улсын төсөв
	3.2. 1:25000-ны масштабын геологи-орчны судалгааны ажлыг гүйцэтгэх.	Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь	0%	0.15%	Улсын төсөв
	3.3. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэж дуусах.	Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь	14%	100%	Улсын төсөв
	3.4. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг зохион байгуулах.	Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь	63%	70%	Улсын төсөв
	3.5. Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг зохион байгуулах.	Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь	65%	100%	Улсын төсөв
	3.6. Бүс нутаг болон хотуудын геоэкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажлыг хийх.	Хэрэгжсэн төслийн тоо	2	7	Улсын төсөв
	3.7. Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн	Хэрэгжсэн төслийн тоо	1	6	Улсын төсөв

	хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажлыг хэрэгжүүлэх.				
	3.8. ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ зэрэг гадаад орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд геологийн судалгааны ажлыг хэрэгжүүлэх.	Хэрэгжсэн төслийн тоо	1	3	Улсын төсөв
	3.9. Гадаад орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг Геологийн албадтай хамтын ажиллагааг сэргээх, харилцан үр ашигтай төсөл хэрэгжүүлэх санал боловсруулах, хэрэгжилтийг хангах	Хэрэгжилтийн хувь	0	100	Улсын төсөв, гадаадын зээл тусламж
	3.10. ЭБМЗ-ийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдааны дүгнэлтэд үндэслэн үр дүнг хүлээн авах	Хүлээн авсан ажлын тоо	5	50	Улсын төсөв
Үндсэн чиг үүрэг-3: Геологи-хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг өсгөх.					
Зорилт-4: Ашигт малтмалын геологи-хайгуулын ажлын хэмжээг нэмэгдүүлэх, улсын эрдэс баялгийн нөөцийг өсгөх ажлыг зохион байгуулах, хяналт тавих.	4.1. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх.	Хэрэгжсэн төслийн тоо	1	3	Улсын төсөв
	4.2. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан, эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх.	Хэрэгжсэн төслийн тоо	1	3	Улсын төсөв
	4.3. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талбайн хил, заагийг Засгийн	Хил зааг нь батлагдсан ордын тоо	8	16	-

	газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах.				
	4.4. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн хил, заагийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах.	Хил заагийг батлуулах ажлын хувь	0	100	-
	4.5. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлэх.	Олгосон тусгай зөвшөөрлийн тоо	33	230	-
	4.6. Ашигт малтмалын хайгуулын ажлыг эрчимжүүлж, геологийн нөөцийг өсгөх.	Улсын нөөцийн бүртгэлд бүртгэгдсэн ордын тоо	2,250	2,330	Хувийн хөрөнгө оруулалт
Үндсэн чиг үүрэг-4: Геологи, эрдэс баялгийн үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх.					
Зорилт-5: Геологийн салбарын нэгдсэн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөгжүүлэх, хуулиар зөвшөөрөгдсөн мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй болгох ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих.	5.1. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг бүх төрлийн геологийн судалгааны ажлын үр дүнгийн мэдээллээр баяжуулах, бүрдүүлэх, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах.	Хэрэгжсэн төслийн тоо	1	2	Улсын төсөв
	5.2. Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах.	Хэрэгжсэн төслийн тоо	0	2	Улсын төсөв
2. Ерөнхий чиг үүргийн нэр: Уул уурхайн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.					
Үндсэн чиг үүрэг-1: Уул уурхайн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох.					
Зорилт-1: Уул уурхайн салбарын хууль тогтоомжийг	1.1. Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн шинэчилсэн	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв

боловсронгуй бодлого, хөтөлбөрийн боловсруулах.	болгох, төсөл, хувилбар	найруулгын төслийг боловсруулж, батлуулах.				
		1.2. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв
		1.3. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв
		1.4. Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв
Үндсэн чиг үүрэг-2: Ашигт малтмалын олборлолт, баяжуулалтын хэмжээг нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх.						
Зорилт-2: Ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйгээр хангах, хэрэгжилтийг зохицуулах.		2.1. Оюутолгойн төслийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд уурхайг ашиглалтад оруулах.	Уурхай байгуулах ажлын явц	26 хувь	100 хувь	Гадаадын шууд хөрөнгө оруулалт, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл
		2.2. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын өмчлөлтэй холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх.	Боловсруулсан хүдрийн хэмжээ	32.0 сая.тн/жил	40 сая.тн/жил	Хувийн хөрөнгө оруулалт, зээл

2.2.1. Мөчлөгт урсгалт тээврийн технологийг нэвтрүүлэх.	Технологи нэвтрүүлэлтийн явц	52 хувь	100 хувь.	Хувийн хөрөнгө оруулалт, зээл
2.2.2. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг ашиглалтад оруулах.	Шинээр ашиглалтад орсон үйлдвэрийн тоо	0	1	Хувийн хөрөнгө оруулалт, зээл
2.2.3. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл.	Өргөтгөл, шинэчлэлийн явц	14 хувь	100 хувь	Хувийн хөрөнгө оруулалт, зээл
2.2.4. Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл.	Өргөтгөл, шинэчлэлийн явц	15 хувь.	100 хувь.	Хувийн хөрөнгө оруулалт, зээл
2.3. Цагаансуваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах.	Ашиглалтад орсон ордын тоо	0	1	Хувийн хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл
2.4. Багануурын уурхайд өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж, өртөг, зардлыг бууруулах.	Олборлосон нүүрсний хэмжээ Үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлийн явц	4.0 сая.тн/жил 51 хувь	5.7 сая.тн/жил 100 хувь	Гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламж

2.5. Шивээ-Овоогийн нүүрсний өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж, өртөг, зардлыг бууруулах.	Олборлосон нүүрсний хэмжээ Үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлийн явц	2.0 сая.тн/жил 36 хувь	2.6 сая.тн/жил 71 хувь	Гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламж
2.6. Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх.	Ашиглалтад орсон ордын тоо	0	1	Хувийн хөрөнгө оруулалт
2.6.1. Асгатын мөнгөний ордыг ашиглах туршилт, судалгаа хийх.	Лабораторын туршилт, судалгааны ажлын гүйцэтгэл	50 хувь.	100 хувь	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
2.6.2. Асгатын мөнгөний ордыг ашиглах зөвлөх үйлчилгээ авах.	Зөвлөх үйлчилгээний ажлын явц	55 хувь	100 хувь	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
2.6.3. Асгатын мөнгөний ордод нэмэлт хайгуул хийх.	Нэмэлт хайгуулын ажлын явц	0 хувь	100 хувь	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
2.6.4. Асгатын мөнгөний ордын дэд бүтэц, бэлтгэл ажил.	Дэд бүтэц, бэлтгэл ажлын явц	0 хувь	100 хувь	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
2.7. Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах.	Баяжуулсан нүүрсний хэмжээ	0	10 сая.тн/жил	Хувийн хөрөнгө оруулалт, зээл

	2.7.1. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийг шинээр нэвтрүүлэх.	Тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлтийн явц	0 хувь.	21 хувь	Хувийн хөрөнгө оруулалт, зээл
	2.7.2. Цанхийн баруун уурхайд хөрсний конвейерийн систем нэвтрүүлэх.	Конвейерийн систем нэвтрүүлэлтийн явц	0 хувь	79 хувь	Хувийн хөрөнгө оруулалт, зээл
	2.7.3. Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1 дүгээр модулийг барьж байгуулах.	Бүтээн байгуулалтын ажлын явц	0 хувь	100 хувь	Хувийн хөрөнгө оруулалт, зээл
	2.7.4. Ачилтын нэгдсэн төв байгуулах.	Бүтээн байгуулалтын ажлын явц	0 хувь	100 хувь	Хувийн хөрөнгө оруулалт, зээл
	2.7.5 Усан хангамжийн системийг барьж байгуулах.	Бүтээн байгуулалтын ажлын явц	0 хувь	100 хувь	Хувийн хөрөнгө оруулалт
	2.8. Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглах.	Боловсруулсан хүдрийн хэмжээ	300.0 мян.тн/жил	600.0 мян.тн/жил	Хувийн хөрөнгө оруулалт
		Төслийн хүчин чадлын ашиглалт	50 хувь	100 хувь	
	2.9. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах.	Ашиглалтад орсон ордын тоо	0	1	Хувийн хөрөнгө оруулалт, зээл

	2.10. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрүүдийг байнгын ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулж, уурхай, үйлдвэрийг ашиглалтад оруулах.	Байнгын ашиглалтад хүлээн авсан уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн тоо	104	184	Улсын төсөв, Хувийн хөрөнгө оруулалт
Үндсэн чиг үүрэг-3: Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх.					
Зорилт-4: Уул уурхайн салбарын ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хэрэгжилтийг зохицуулах, байгууллагын дэргэдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороодын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах.	4.1. Уул уурхайн салбарын ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг хангах.	Боловсруулсан хөтөлбөрийн тоо	0	3	Улсын төсөв
Зорилт-5: Байгаль орчныг хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын менежментийн төлөвлөлтөд үнэлэлт дүгнэлт өгөх, хэрэгжилтийг хангуулах.	5.1. Уурхайн нөхөн сэргээлт, уурхайн хаалтын менежментийн төлөвлөлтөд үнэлэлт, дүгнэлт өгөх, хэрэгжилтийг хангуулах.	Хаалтын менежментийн төлөвлөлтийн тоо	2	6	Улсын төсөв

Зорилт-6: Уул уурхайн салбарын судалгаа, шинжилгээ, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх.	6.1. “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв”-ийг байгуулах.	Шинээр байгуулагдсан далд уурхайн музейн тоо	0	1	Улсын төсөв, хувийн хөрөнгө оруулалт
3. Ерөнхий чиг үүргийн нэр: Газрын тосны салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.					
Үндсэн чиг үүрэг-1: Газрын тосны салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах.					
Зорилт-1: Газрын тосны салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах.	1.1.Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв
	1.2. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв
	1.3. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв
	1.4. Газрын тосны салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, холбогдох бусад журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангах.	Боловсруулсан журмын тоо	0	1	Улсын төсөв, Гадаадын зээл тусламж
Үндсэн чиг үүрэг 2: Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, нөөц тогтоох, ашиглалт, олборлолтыг нэмэгдүүлэх.					
Зорилт 2: Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл,	2.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг	Хөрөнгө оруулалтын хэмжээ	43.9 тэрбум.төг	283.7 тэрбум.төг	Хувийн хөрөнгө оруулалт

хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх, эрлийн гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах, нөөц тогтоох.	нэмэгдүүлж, хэтийн төлөв тодорхойлох.				
	2.2. Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах.	Шинээр байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний тоо	23	32	Хувийн хөрөнгө оруулалт
	2.3. Газрын тосны хайгуулын талбайд шинээр орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулах.	Нөөц тогтоосон хайгуулын талбайн тоо	0	1	Хувийн хөрөнгө оруулалт
	2.4. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.	Олборлосон тосны хэмжээ	400 мян.тн	900 мян.н	Хувийн хөрөнгө оруулалт
Үндсэн чиг үүрэг: 3: Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах.					
Зорилт 3: Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг дамжуулах хоолойн хамт барьж байгуулах.	3.1.Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх.	Шинээр баригдсан дамжуулах хоолой	0	1	Засгийн газрын баталгаатай зээл, хувийн хөрөнгө оруулалт
	3.2.Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах.	Шинээр байгуулагдсан үйлдвэрийн тоо	0	1	Гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламж
Үндсэн чиг үүрэг: 4: Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах.					

Зорилт-4: Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах.	4.1. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг тогтвортой нэмэгдүүлэх.	Бүтээгдэхүүний хэмжээ	2.0 сая тонн	2.4 сая тонн	Хувийн хөрөнгө оруулалт
	4.2."Евро-5" стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.	Евро-5 стандартын шатахууны эзлэх хувь	13 хувь	50 хувь	Хувийн хөрөнгө оруулалт
	4.3."Шатдаг хийн хадгалалт, түгээлтийн үеийн техник ашиглалт, аюулгүй ажиллагаатай холбогдсон стандарт, дүрмийг боловсронгуй болгох.	Баримт бичиг боловсруулалтын хувь	0 хувь	100 хувь	Улсын төсөв
4. Ерөнхий чиг үүргийн нэр: Хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.					
Үндсэн чиг үүрэг-1: Хүнд үйлдвэрийн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах.					
Зорилт-1: Хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах.	1.1. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв
	1.2. Хүнд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв
	1.3. Хүнд үйлдвэрийг хөгжүүлэхэд шаардлагатай ус хангамж, эрчим хүч, тээвэр ложистик зэрэг дэд бүтцийн төлөвлөлт, судалгаа боловсруулах.	Боловсруулсан судалгаа, баримт бичгийн тоо	1	4	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж

	1.4. Хүнд үйлдвэрийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, холбогдох бусад журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангах.	Боловсруулсан журмын тоо	1	4	Улсын төсөв, зээл тусламж
Үндсэн чиг үүрэг-2: Тэргүүний технологи, инновацийг нэвтрүүлэх, нутагшуулах, дамжуулах, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах замаар хүнд үйлдвэрийг хөгжүүлэх.					
Зорилт-2: Хүнд үйлдвэрлэлийг цогцолбороор хөгжүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний сүлжээг бий болгоно.	2.1. Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах.	Үйлдвэр байгуулах ажлын явц	0 хувь	100 хувь	Хувийн хөрөнгө оруулалт
	2.2. Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад оруулах.	Үйлдвэр байгуулах ажлын явц	75.8 хувь	100 хувь	Хувийн хөрөнгө оруулалт
	2.3. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах.	Үйлдвэр байгуулах ажлын явц	16.4 хувь	100 хувь	Хувийн хөрөнгө оруулалт
	2.4. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах /"Болдтөмөрөрөөгол" ХХК/.	Үйлдвэр байгуулах ажлын явц	20 хувь	80 хувь	Хувийн хөрөнгө оруулалт
	2.5. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах.	Үйлдвэр байгуулах ажлын явц	5 хувь	100 хувь	Хувийн хөрөнгө оруулалт, зээл
	2.6. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барих.	Үйлдвэр байгуулах ажлын явц	0 хувь	95 хувь	Хувийн хөрөнгө оруулалт, зээл

	2.7. Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын УТП байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулах.	Үйлдвэр байгуулах ажлын явц	0 хувь	100 хувь	Хувийн хөрөнгө оруулалт, зээл
	2.8. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах.	Үйлдвэр байгуулах ажлын явц	0 хувь	100 хувь	Гадаадны шууд хөрөнгө оруулалт
	2.9. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмалыг боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх.	Үйлдвэр байгуулах ажлын явц	0.2 хувь	20 хувь	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
Ерөнхий чиг үүрэг-1: Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, зохицуулах, хэрэгжүүлэх.					
Үндсэн чиг үүрэг-1: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.					
Зорилт-1: Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, аппаратын дотоод ажил болон олон нийттэй харилцах, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах.	1.1. Яамны дотоод ажил болон олон нийттэй харилцах, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэн гаргах, тайлагнах.	Үйл ажиллагааны үнэлгээний хувь	92 хувь	95 хувь	Улсын төсөв
Үндсэн чиг үүрэг-2: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэй боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах.					

<p>Зорилт-2: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө, боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах.</p>	<p>2.1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хүний нөөцийн хөгжлийн стратегийн баримт бичгийн төслийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах.</p>	<p>Батлуулсан баримт бичгийн тоо</p>	<p>0</p>	<p>1</p>	<p>Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж</p>
<p>Үндсэн чиг үүрэг-3: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн талаар олон нийтэд сурталчилан таниулах.</p>					
<p>Зорилт-3: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн боловсруулах бусад эрх зүйн актын төсөл боловсруулах, өргөн барихад дэмжлэг үзүүлэх.</p>	<p>3.1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн боловсруулах бусад эрх зүйн актын төсөл боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах.</p>	<p>Боловсруулсан хууль тогтоомж, эрх зүйн актын тоо</p>	<p>108</p>	<p>112</p>	<p>Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж</p>
<p>Үндсэн чиг үүрэг-4: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх.</p>					
<p>Зорилт-4: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын гэрээний талаар гадаад орон, олон</p>	<p>4.1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт татах чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хоёр болон олон талт</p>	<p>Байгуулсан гэрээ, хэлэлцээрийн тоо</p>	<p>3</p>	<p>7</p>	<p>Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж</p>

улсын эрх зүй, туршлагыг судлах, санал гаргах, дэмжлэг үзүүлэх.	хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр, санамж бичиг байгуулах.				
Үндсэн чиг үүрэг-5: Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх.					
Зорилт-5: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, сайдын төсвийн багцыг төлөвлөх, зохицуулах, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулж, үйлчилгээ үзүүлэх.	5.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд (ТЭЗ)-ын төсвийн багцыг төлөвлөх, зохицуулах, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулах.	Боловсруулсан төсвийн төслийн тоо	1	4	Улсын төсөв
	5.2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд (ТЭЗ)-ын төсвийн багцын санхүүгийн тайланг нэгтгэн баталгаажуулах, тайланг холбогдох газарт хүргүүлэх.	Хүргүүлсэн тайлангийн тоо	1	4	Улсын төсөв
	5.3. ТЭЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн ил тод байдлыг хангаж ажиллах.	Хүргүүлсэн тайлангийн тоо	1	4	Улсын төсөв
Ерөнхий чиг үүрэг-1: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах, хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, бодлого, чиглэлийг тодорхойлох болон энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад бүх талын дэмжлэг үзүүлэх, зохицуулах, тайлагнах.					
Үндсэн чиг үүрэг-1: Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын бодлого, чиглэлийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах ажлыг зохион байгуулах.					

Зорилт-1: Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомж, төсөл, хөтөлбөр, зөвлөмжийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх.	1.1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын орчинг сайжруулахтай холбоотой хууль тогтоомж, хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.	Батлагдсан хууль тогтоомжийн тоо Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо	1 0	3 2	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж
	1.2. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн (тодотгол) төслийг боловсруулах, хөтөлбөрт туссан төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	Боловсруулсан хөтөлбөрийн (тодотгол) тоо	1	3	Улсын төсөв
Зорилт-2: Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах.	2.1 Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг тодорхойлох, үр ашгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах.	Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо	1	3	Гадаадын зээл, тусламж
Үндсэн чиг үүрэг 2: Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, судалгаа, мэдээллээр хэрэглэгчийг хангах.					
Зорилт-3: Хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх.	3.1. Хөрөнгө оруулалтын томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа боловсруулах, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх.	Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо	9	13	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж

Зорилт-4: Салбарын хөрөнгө оруулалт, татвар, бүтээгдэхүүний худалдаа, экспортын талаар судалгаа хийх, статистик мэдээллээр хэрэглэгчийг хангах.	4.1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын статистик мэдээллийг долоо хоног, сар, улирал, жилээр нэгтгэн боловсруулах, тайлагнах, хэрэглэгчийг мэдээллээр шуурхай хангах.	Боловсруулсан статистик, мэдээллийн тоо	12	64	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж
	4.2. Экспортод гаргаж буй ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох жишиг үнийг батлах, нийтэд мэдээлэх.	Зарласан жишиг үнийн тоо	12	48	Улсын төсөв
7. Ерөнхий чиг үүргийн нэр: Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах					
Үндсэн чиг үүрэг-1: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж боловсруулах, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах.					
Зорилт-1: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох байгууллагуудад хүргүүлэх.	1.1. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгч, тайланг холбогдох газарт хүргүүлэх.	Зорилтот түвшин, хүрсэн түвшин хоорондын зөрүү	3.4	1.5	Улсын төсөв

Зорилт-2: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах.	2.1. Яамны дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит хийх.	Хийгдсэн аудитын тоо	0	5	Улсын төсөв
Үндсэн чиг үүрэг-2: УУХҮЯ, АМГТГ, ҮГА-ны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.					
Зорилт-3: “Эрдэс баялгийн цахим засаглал” хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах.	3.1. “Эрдэс баялгийн цахим засаглал” үндэсний арга хэмжээний төсөл боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах.	Боловсруулсан төсөл, хөтөлбөрийн тоо	0	1	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж
Зорилт-4:Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн үйлчилгээг цахимжуулж, түргэн шуурхай хүргэх.	4.1. УУХҮЯ, АМГТГ, ҮГА-аас олгодог тусгай зөвшөөрлүүд болон ЭБМЗ-ийн үйл ажиллагааг цахимжуулах, “E-Mongolia” платформд нэгдэх, аппликейшн нэвтрүүлэх.	Шинээр нэвтрүүлсэн аппликейшин	0	1	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж

--o00o--